ТҮҮВЭР СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Судалгааны сэдэв: "Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдлын талаарх түүвэр судалгаа"

Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд макро эдийн засаг, нийгэм, бизнесийн орчны нөлөө болон тэдгээрийн орлого, зардалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор тус түүвэр судалгааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүдээс мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх судалгааны баг, байгууллагыг холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

Судалгааны ажлын нэмэлт мэдээлэл, бүрдүүлэх материал:

Хамрах хүрээ:	Улаанбаатар хот, Төв аймагт идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд
Судалгааны баг:	• Судалгааны мэдээлэл цуглуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд • Их, дээд сургуулийн багш нар
Түүврийн хэмжээ:	• 1,530 аж ахуйн нэгж (*үүнээс Төв аймагт 30 ААН*)
Судалгааны ажил хийх хугацаа:	• 2023 оны 10-р сарын 02-ны өдрөөс 10-р сарын 20-ны өдрүүдэд
Давтамж:	• 1 удаа
Судалгааг авах хэлбэр:	• Ярилцлага болон утсаар ярих хэлбэрээр
Гүйцэтгэх ажил, хүлээгдэх үр дүн:	• Улаанбаатар хот, Төв аймгийн аж ахуйн нэгжүүдээс асуулга авна. • Монголбанкны орон нутгийн салбаруудын авсан мэдээллийн хамт нэгтгэн ирүүлнэ. Түүвэр судалгааны мэдээлэл нь үнэн зөв, бодитой, шаардлагад нийцсэн байх.
Бүрдүүлэх материал:	Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь дараах материалуудыг ирүүлнэ: • Хуулийн этгээдийн танилцуулга, хүний нөөцийн чадавх болон түүвэр судалгааны чиглэлээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байсан тухай танилцуулга • Ажил гүйцэтгэх техникийн санал • Ажил гүйцэтгэх санхүүгийн санал

Холбогдох материалаа дор дурдсан хаягаар **2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 18:00 цагаас өмнө** ирүүлнэ үү. Тус ажлын талаарх нэмэлт мэдээллийг ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Монголбанкны 11-324060 дугаараас авч болно.

Цахим шуудан: survey@mongolbank.mn

Хаяг: Монголбанк, Судалгаа, статистикийн газар, Бага тойруу 3, 15160 Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг